



**“АДУУНЧУЛУУН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

№24/03

Огноо: 2024.03.21

Цаг: 09:00-12:00 хүртэл

Байршил: Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, “Адуунчулуун” ХК-ийн Хурлын танхимд.

Хурлын дарга: Ц.Шижир

Хурлын нарийн бичгийн дарга: А.Оюун-Эрдэнэ

Хуралд оролцсон гишүүдийн тоо: 9

Хурлын ирц: 100%

Хурлын ирц бүрэн. Б.Батсайхан, Б.Ганчулуун гишүүн онлайнаар оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцан хэлэлцэж дүгнэлт гаргах- КтХ-76.1.11
2. 2023 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх
3. Нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн зөвлөмж, дүгнэлттэй танилцах
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах – КтХ-76.1.2, 76.1.3

Танилцуулга хийсэн: Ц.Шижир /ТУЗ-ийн дарга/

Танилцуулгын гол агуулга: Хурлын дэг

1 дэх асуудал: 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцан хэлэлцэж дүгнэлт гаргах-КтХ-76.1.11

Танилцуулга хийсэн: Ш.Баясгалан

Танилцуулгын гол агуулга: Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан /презентация/, СЗХорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225-р тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4-р хавсралтын дагуу “Жилийн үйл ажиллагааны тайлагнал” маягт-1-ээр хийсэн тайлан. 2023 оны санхүүгийн төлөвлөгөө, гүйцэтгэл.

Асуулт, Хариулт

С.Бадарч: Алдагдал 6 дахин нэмэгдсэн нь маш ноцтой зүйл. Зардал нэмэгдсэн байна. Үүнийг асууя.

Ш.Баясгалан: Шатах тослох материал, түлш, сэлбэгийн үнийн өөрчлөлтүүд нөлөөлж байгаа. Дээрээс нь хөрс хуулалтын ажил хүйтэрснээс болж удааширсан, техник хэрэгслүүд эвдэрсэн асуудлууд маш их байна.

С.Бадарч: Зардал аа бууруулах ямар арга байна. Орлого нэмэгдүүлэх эх үүсвэр юу байна. Энэ жилийн бизнес төлөвлөгөөнд ямар шинэ санаа байна. Удирдлагууд ямар бодолтой байна?

Ш.Баясгалан: Нүүрсний үнээ нэмүүлэх арга л байна. Үнэ нэмэгдэж жаахан хуримтлал үүсэж асуудлуудаасаа гарна. Дээрээс нь газар гэсээд ирэхлээр хөрс хуулалтын ажил эхэлнэ.



Ц.Шижир: Зардлын задаргаагаа нэлээн сайн гаргах хэрэгтэй байна хувьцаа эзэмшигчдийн хуралд.

С.Бадарч: Орлого нэмэгдүүлнэ гэхээр үнээ нэмээд орлого нэмнэ гэх юм. Энэ бол зүгээр нэг яриад шийддэг зүйл биш.

Ш.Баясгалан: Орлого нэмэгдүүлэх тал дээр өнөөдөр тэрэнд зарах хөрөнгө алга байна. Алдагдалтай ажиллаад байгаа үед бүр хэцүү. Алдагдалгүй жаахан ч гэсэн хуримтлал үүсэж байж 2 дахь орлогын талаар ярина шүү дээ.

Б.Батсайхан: Үнийн асуудлаа тавьсаар байх хэрэгтэй. Бүх юмны үнэ энэ хугацаанд өчнөөн нэмэгдсэн байна.

Ш.Идэр: Б.Батсайхан гишүүнтэй санал нэг байна.

Б.Ганчулуун: Жил бүр сэлбэг, бараа материал дээрээ хяналтаа сайжруулаад байгаа нь харагдаад байгаа боловч үнэ нэмэгдээд байхаар аргагүй л дээ. Хаа сайгүй л үнийн өсөлтийг ярьж байна.

Танилцуулга хийсэн: Ц.Шижир /ТУЗ-ийн дарга/

Танилцуулгын гол агуулга: “Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай” тогтоолын төслийг уншиж танилцуулав.

2 дахь асуудал: 2023 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх

Танилцуулга хийсэн: Ц.Шижир /ТУЗ-ийн дарга/

Танилцуулгын гол агуулга: 2023 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан /презентация/

Асуулт, Хариулт

С.Бадарч: ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажлууд нэлээн идэвхигүй болж байна. Хороодын гишүүний бүрэлдэхүүн 3 байсныг 5 болгож бусад хорооны мэдээлэл авах, хурлын идэвх оролцоо өөр болсон боловч өнгөрсөн жилийн хувьд идэвхи муу байсан учраас хороодыг шинэчлэн сольсон нь зөв байх.

3 дахь асуудал: Нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн зөвлөмж, дүгнэлттэй танилцах

Танилцуулга хийсэн: Ш.Идэр /Нэр дэвшүүлэх хорооны дарга/

Танилцуулгын гол агуулга: Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтын дагуу 5-с дээш хувийн хувьцаа эзэмшигчигчдийн санал ирээгүй болно.

Ш.Идэр: Нийт 13 нэр дэвшигч.

1. Ердийн гишүүнд

- Ц.Шижир
- Ш.Баясгалан
- Ш.Идэр
- Б.Батсайхан
- С.Бадарч
- Л.Батмөнх

2. Хараат бус гишүүнд

- Б.Ганчулуун
- Б.Ганхуяг
- Б.Энхбаатар
- Т.Даваасүрэн
- Т.Даш-Эрдэнэ
- Б.Эрдэнэбилэг
- - Ю.батбаатар

Үүнээс дараах гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлэхээр хороо шийдвэрлэсэн.



Ердийн гишүүнд:

- Ц.Шижир
- С.Бадарч
- Ш.Баясгалан
- Б.Батсайхан,
- Ш.Идэр
- Л.Батмөнх

Хараат бус гишүүнд:

- Б.Ганхуяг
- Б.Энхбаатар
- Б.Эрдэнэбилэг

Дараах гишүүдээс дараах үндэслэлээр татгалзсан. Үүнд:

1. Б.Ганчулуун– Компанийн тухай хуулийн 79.1.5 дахь заалт, Компанийн дүрмийн 7.24 дахь заалтаар.
2. Т.Даваасүрэн- Компанийн тухай хуулийн 79.1.5 дахь заалт, Компанийн дүрмийн 7.24 дахь заалтаар.
3. Т.Даш-Эрдэнэ- Компанийн тухай хуулийн 79.1.5 дахь заалт, Компанийн дүрмийн 7.24 дахь заалтаар.

ГУРАВ. Ю.Батбаатар нь өөрийн хүсэлтээр татгалзсан болно.

4 дэх асуудал: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах –КтХ-76.1.2, 76.1.3

Танилцуулга хийсэн: Ц.Шижир /ТУЗ-ийн дарга/

Танилцуулгын гол агуулга: “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай” тогтоолын төслийг хавсралтуудын хамт, 377-р тогтоолын 1-р хавсралт “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бүх гишүүдийн 100 хувийн саналаар хангалттай гэж дүгнэж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг ТУЗ-ийн дарга /Ц.Шижир/-д даалгав.
2. Компанийн ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг ТУЗ-ийн дарга /Ц.Шижир/-д даалгав.
3. Нэр дэвшүүлэх хорооны дүгнэлт, зөвлөмжийг арилжаа эрхлэх байгууллагад явуулахыг ТУЗ-ийн нарын бичгийн дарга /А.Оюун-Эрдэнэ/-д даалгав.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14:00 цагт Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, компанийн хурлын танхимд халдвар хамгаалалтын дэглэмийг чанд сахин зохион байгуулахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:

ТУЗ-ИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

Ц. Шижир

С. Бадарч

Ш. Баясгалан

Б. Батсайхан

Ц.ШИЖИР



С.БАДАРЧ

Ш.БАЯСГАЛАН


Б.БАТСАЙХАН

Ю.БАТБААТАР



 Б.ГАНЧУЛУУН
Ш.ИДЭР
 Т.ДАВААСҮРЭН
Т.ДАШ-ЭРДЭНЭ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

 А.ОЮУН-ЭРДЭНЭ